

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН 2020 ОНЫ ЖИЛИЙН
ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Аудитын код: ХОА-2021/83/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Ховд хот 2021 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг: Tsetsegsuren.A@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Нарантуул Утас: 70432545 цахим хаяг: Narantuul.d@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

<i>АДБОУС</i>	<i>Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт</i>
<i>АОУС</i>	<i>Аудитын Олон Улсын Стандарт</i>
<i>УСНББОУС</i>	<i>Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт</i>
<i>ТТЗ</i>	<i>Төсвийн төвлөрүүлэн захирагч</i>
<i>ТШЗ</i>	<i>Төсвийн шууд захирагч</i>
<i>ТӨБЗГ</i>	<i>Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар</i>
<i>ХХААГ</i>	<i>Хүнс хөдөө аж ахуйн газар</i>

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	10
3. Аудитын тайлан	10
3.1. Ерөнхий зүйл	10
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт.....	11
3.4. Материаллаг байдал	12
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	12
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	13
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	14
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.9. Аудитын илрүүлэлт.....	14
Залруулсан алдаа	15
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил.....	
Аудитын зөвлөмж	15
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	15
4. Менежментийн захидал	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	16

1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав бөг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433081, Факс: 976-70433081
E-mail: khovd@audit.gov.mn

2021.02.03 № 4/21
танай _____ -ны № _____ -т

ХӨДӨЛМӨР ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА
Л.БИЛЭГДЭМБЭРЭЛ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2020 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.БОЛДБААТАР

᠒᠒᠑᠐20126

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>75,455,782.00</u>	<u>43,419,765.74</u>
33	АВЛАГА	5,691,200.94	4,077,838.68
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	6,000	-
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	5,685,200.94	4,077,838.68
35	БАРАА МАТЕРИАЛ	69,764,581.06	39,341,927.06
351	Түүхий эд материал	35,000	76,500
35130	Эм боох материал	35,000	76,500
354	Хангамжийн материал	69,729,581.06	39,265,427.06
35410	Бичиг хэргийн материал	9,623,900	1,654,000
35420	Аж ахуйн материал	4,101,100	1,666,996
35430	Сэлбэг хэрэгсэл	2,489,000	2,148,000
35440	Түлш, шатах тослох материал	-	1,485,000
35460	Хүнсний материал	790,851	150,051
35470	Бусад хангамжийн материал	52,724,730.06	32,161,380.06
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>748,401,885.07</u>	<u>709,636,211.15</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	748,401,885.07	709,636,211.15
392	Биет хөрөнгө	689,136,676.60	654,873,711.15
39201	Барилга, байгууламж, орон сууц	636,483,028	636,483,028
39202	Хуримтлагдсан элэгдэл	(47,436,917.01)	(64,614,347.85)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	80,000,000	80,000,000
39204	Хуримтлагдсан элэгдэл	(75,833,333.04)	(80,000,000)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	212,312,937.07	231,717,987.07
39206	Хуримтлагдсан элэгдэл	(149,880,007.12)	(173,235,384.87)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	92,612,281	90,422,281
39208	Хуримтлагдсан элэгдэл	(59,246,312.30)	(66,024,852.20)
39217	Ном	125,000	125,000
393	Биет бус хөрөнгө	59,265,208.47	54,762,500
39301	Програм хангамж	23,735,000.00	24,175,000
39302	Хуримтлагдсан элэгдэл	(9,469,791.53)	(14,412,500)
39303	Бусад биет бус хөрөнгө	45,000,000	45,000,000
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>823,857,667.07</u>	<u>753,055,976.89</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>823,857,667.06</u>	<u>753,055,976.89</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	823,857,667.06	753,055,976.89
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	216,668,324	216,668,324
51101	Өмч: - төрийн	216,668,324	216,668,324
512	Хуримтлагдсан үр дүн	583,853,728.62	513,052,038.45
51210	Өмнөх үеийн үр дүн	583,853,728.62	583,853,728.62
51220	Тайлант үеийн үр дүн	-	(70,801,690.17)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	23,335,614.44	23,335,614.44
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>823,857,667.06</u>	<u>753,055,976.89</u>

2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	944,452,806.45	837,265,450
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	267,790,472	73,439,050
120	Нийтлэг татварын бус орлого	267,790,472	73,439,050
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	267,790,472	73,439,050
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	58,535,000	40,504,000
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	209,255,472	32,935,050
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	676,662,334.45	763,826,400
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	642,934,500	736,030,900
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	642,934,500	736,030,900
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	33,727,834.45	27,795,500
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,096,454.45	10,870,500
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	32,631,380	16,925,000
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	962,209,316.20	907,629,140.17
21	УРСГАЛ ЗАРДАЛ	962,209,316.20	907,629,140.17
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	936,232,316.20	879,426,640.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	506,291,213	583,470,601.73
210101	Үндсэн цалин	398,720,413	445,165,602.49
210102	Нэмэгдэл	89,910,200	121,075,285.82
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,660,600	17,229,713.42
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	67,081,843.81	77,530,327.46
210201	Тэтгэврийн даатгал	46,268,399.65	55,562,422.98
210202	Тэтгэмжийн даатгал	5,295,343.56	5,339,086.76
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,233,797.37	4,271,270.81
210204	Ажилгүйдлийн даатгал	1,049,641.02	964,068.81
210205	Эрүүл мэндийн даатгал	10,234,662.22	11,393,478.11
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,553,900	36,071,700
210301	Гэрэл, цахилгаан	4,718,460	4,429,600
210302	Түлш, халаалт	23,364,297	26,120,600
210303	Цэвэр, бохир ус	3,471,143	5,521,500
2104	Хангамж, бараа материалын зардал	156,228,487.45	46,252,500
210401	Бичиг хэрэг	72,887,439.45	22,245,900
210402	Тээвэр, шатахуун	47,489,898	7,480,150
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,624,000	2,515,600
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	461,000
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	33,227,150	13,549,850
2105	Нормативт зардал	54,160,309	22,939,466.17
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	459,412	1,406,866.17
210502	Хоол, хүнс	52,625,397	20,727,600
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,075,500	805,000
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,698,690	11,487,550
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,771,190	9,804,150

210604	Урсгал засвар	927,500	1,683,400
2107	Томилолт, зочны зардал	11,830,600	4,250,000
210702	Дотоод албан томилолт	11,830,600	4,250,000
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	38,273,850	28,142,770.89
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	34,977,750	24,357,470.89
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,485,000	1,485,000
210803	Даатгалын үйлчилгээ	623,700	1,415,000
210804	Тээврийн хэрэгслийн татвар	297,000	250,000
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	29,700	67,000
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	662,700	305,300
210807	Газрын төлбөр	198,000	263,000
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	68,113,422.94	69,281,723.92
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	9,020,000
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	172,000.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	67,941,422.94	60,261,723.92
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,977,000	28,202,500
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,317,000	20,404,500
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	20,767,000	19,354,000
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,550,000	1,050,500
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,660,000	7,798,000
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,660,000	7,798,000
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(17,756,509.75)	(70,363,690.17)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	438,000
225003	Хөрөнгө оруулалтын гарз	-	438,000
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(438,000)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(17,756,509.75)	(70,801,690.17)

2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	732,090,334.45	804,821,400
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	55,428,000	40,995,000
120	Нийтлэг татварын бус орлого	55,428,000	40,995,000
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	55,428,000	40,995,000
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	53,244,000	40,504,000
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	2,184,000	-
120009	Бусад орлого	-	491,000
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	676,662,334.45	763,826,400
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	642,934,500	736,030,900
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	642,934,500	736,030,900
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	33,727,834.45	27,795,500
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,096,454.45	10,870,500

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	32,631,380	16,925,000
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	732,090,334.45	804,821,400
21	УРСГАЛ ЗАРДАЛ	732,090,334.45	804,821,400
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	706,113,334.45	776,623,900
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	507,293,000	583,991,300
210101	Үндсэн цалин	399,722,200	445,616,300
210102	Нэмэгдэл	89,910,200	121,075,286.58
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,660,600	17,299,713.42
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	63,411,800	78,029,800
210201	Тэтгэврийн даатгал	43,120,000	55,141,000
210202	Тэтгэмжийн даатгал	5,072,900	5,722,200
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,212,400	4,577,700
210204	Ажилгүйдлийн даатгал	1,860,600	1,144,500
210205	Эрүүл мэндийн даатгал	10,145,900	11,444,400
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,553,900	36,071,700
210301	Гэрэл, цахилгаан	4,718,460	4,429,600
210302	Түлш, халаалт	23,364,297	26,120,600
210303	Цэвэр, бохир ус	3,471,143	5,521,500
2104	Хангамж, бараа материалын зардал	24,885,754.45	21,088,850
210401	Бичиг хэрэг	5,565,169.45	6,302,000
210402	Тээвэр, шатахуун	14,705,605	8,965,150
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,558,080	2,673,600
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	540,700
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,056,900	2,607,400
2105	Нормативт зардал	21,565,000	22,993,116.17
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	448,912	1,466,366.17
210502	Хоол, хүнс	19,769,088	20,086,750
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,347,000	1,440,000
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,437,000	4,064,396
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,501,340	2,791,996
210604	Урсгал засвар	935,660	1,272,400
2107	Томилолт, зочны зардал	11,830,600	4,250,000
210702	Дотоод албан томилолт	11,830,600	4,250,000
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	42,024,280	26,134,737.83
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	38,668,180	22,220,437.83
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,485,000	1,485,000
210803	Даатгалын үйлчилгээ	623,700	1,415,000
210804	Тээврийн хэрэгслийн татвар	297,000	250,000
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	29,700	67,000
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	722,700	434,300
210807	Газрын төлбөр	198,000	263,000
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	112,000	-

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	112,000	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,977,000	28,197,500
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,317,000	20,399,500
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	20,767,000	19,354,000
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,550,000	1,045,500
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,660,000	7,798,000
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,660,000	7,798,000

2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	216,668,324	23,335,614.44	583,853,728.62	823,857,667.06
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	216,668,324	23,335,614.44	583,853,728.62	823,857,667.06
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	216,668,324	23,335,614.44	583,853,728.62	823,857,667.06
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	216,668,324	23,335,614.44	583,853,728.62	823,857,667.06
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(70,801,690.17)	(70,801,690.17)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	216,668,324	23,335,614.44	513,052,038.45	753,055,976.89

2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН / төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	698,362,500	698,362,500	803,333,500	773,543,400
21	УРСГАЛ ЗАРДАЛ	698,362,500	698,362,500	803,333,500	773,543,400
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	675,045,500	675,045,500	779,681,000	753,143,900
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	507,293,000	507,293,000	583,991,300	583,991,300
210101	Үндсэн цалин	399,722,200	399,722,200	445,616,300	445,616,300
210102	Нэмэгдэл	89,910,200	89,910,200	120,714,400	121,075,286.58
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,660,600	17,660,600	17,660,600	17,299,713.42
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	63,411,800	63,411,800	78,029,800	78,029,800
210201	Тэтгэврийн даатгал	43,120,000	43,120,000	55,141,000	55,141,000
210202	Тэтгэмжийн даатгал	5,072,900	5,072,900	5,722,200	5,722,200
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,058,400	3,212,400	4,577,700	4,577,700
210204	Ажилгүйдлийн даатгал	1,014,600	1,860,600	1,144,500	1,144,500
210205	Эрүүл мэндийн даатгал	10,145,900	10,145,900	11,444,400	11,444,400
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,553,900	31,553,900	36,071,700	36,071,700
210301	Гэрэл, цахилгаан	6,008,900	4,718,460	4,429,600	4,429,600
210302	Түлш, халаалт	22,080,200	23,364,297	26,120,600	26,120,600

210303	Цэвэр, бохир ус	3,464,800	3,471,143	5,521,500	5,521,500
2104	Хангамж, бараа материалын зардал	11,139,300	11,139,300	11,752,300	10,726,350
210401	Бичиг хэрэг	2,896,800	2,962,220	2,647,000	2,647,000
210402	Тээвэр, шатахуун	4,190,700	4,589,100	4,326,400	3,704,650
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,994,900	1,531,080	1,248,600	1,248,600
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	-	518,700	518,700
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,056,900	2,056,900	3,011,600	2,607,400
2105	Нормативт зардал	21,085,200	21,085,200	28,483,200	17,089,116.17
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,108,000	448,912	1,440,000	1,314,366.17
210502	Хоол, хүнс	18,603,200	19,289,288	25,603,200	14,334,750
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,374,000	1,347,000	1,440,000	1,440,000
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,437,000	3,437,000	6,544,600	4,064,396
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,496,500	2,501,340	3,855,600	2,791,996
210604	Урсгал засвар	940,500	935,660	2,689,000	1,272,400
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	34,679,200	34,679,200	34,808,100	23,171,237.83
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	31,323,100	31,323,100	30,893,800	19,256,937.83
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,485,000	1,485,000	1,485,000	1,485,000
210803	Даатгалын үйлчилгээ	623,700	623,700	1,415,000	1,415,000
210804	Тээврийн хэрэгслийн татвар	297,000	297,000	250,000	250,000
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	29,700	29,700	67,000	67,000
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	722,700	722,700	434,300	434,300
210807	Газрын төлбөр	198,000	198,000	263,000	263,000
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,317,000	23,317,000	23,652,500	20,399,500
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,317,000	23,317,000	23,652,500	20,399,500
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	20,767,000	20,767,000	22,607,000	19,354,000
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,550,000	2,550,000	1,045,500	1,045,500
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	698,362,500	698,362,500	803,333,500	773,543,400
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	698,362,500	698,362,500	736,030,900	732,548,400
131001	Улсын төсвөөс санхүүжих	642,934,500	642,934,500	736,030,900	732,548,400
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	55,428,000	55,428,000	67,302,600	40,995,000
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	55,428,000	55,428,000	67,302,600	40,504,000
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	51	51	51	51
620001	Удирдах ажилтан	1	1	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	41	41	41	41
620003	Үйлчлэх ажилтан	9	9	9	9
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	51	51	51	51
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	42	42	42	42
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	9	9	9	9

2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	31,067,834.45	27,795,500
21	УРСГАЛ ЗАРДАЛ	31,067,834.45	27,795,500
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	31,067,834.45	23,480,000
2104	Хангамж, бараа материалын зардал	13,746,454.45	10,362,500
210401	Бичиг хэрэг	2,602,949.45	3,655,000
210402	Тээвэр, шатахуун	10,116,505	5,260,500
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,027,000	1,425,000
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		22,000
2105	Нормативт зардал	479,800	5,904,000
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		152,000
210502	Хоол, хүнс	479,800	5,752,000
2107	Томилолт, зочны зардал	9,384,500	4,250,000
210702	Дотоод албан томилолт	9,384,500	4,250,000
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,345,080	2,963,500
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,345,080	2,963,500
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	112,000	-
213503	Төвлөрүүлэн шилжүүлэг		4315500
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	112,000	-
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	31,067,834.45	27,795,500
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	31,067,834.45	27,795,500
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		10,870,500
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	31,067,834.45	16,925,000

3. АУДИТЫН ТАЙЛАН

3.1. Ерөнхий зүйл

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг газрын дарга Л.Билэгдэмбэрэл танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд бараа материал, авлага барагдуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 01-нээс 2021 оны 02 дугаар сарын 03-ны хооронд Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Нарантуул хариуцаж хэрэгжүүлэв.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь “хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажилгүйдлийг бууруулах, иргэдэд нийгмийн халамжийн үйлчилгээг чанартай, үр дүнтэй шуурхай хүргэх замаар нийгмийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэгдсэн хөдөлмөр халамжийн үйлчилгээний төрийн бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх” гэсэн зорилго, зорилтыг дэвшүүлэн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- *Хүн амын хөдөлмөрлөх эрхийг хангах боломж, нөхцөлийг бүрдүүлж, ажиллах хүчний мэргэжлийн ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх,*
- *Халамжийн үйлчилгээний бодлогын хэрэгжилтийг хангах*
- *Төрийн үйлчилгээг ил тод, нээлттэй, тэгш шударга, чанартай хүргэх*
- *Халамжийн үйлчилгээний цахим мэдээллийн нэгдсэн сүлжээг боловсронгуй болгож, төрийн зохих байгууллагуудын сүлжээ, мэдээлэлтэй нэгдмэл байдлыг хангах*

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт*
- *Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”*
- *Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”*
- *Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай*
- *Хөдөлмөр, нийгмийн хамгаалал, Сангийн сайдын 2020 оны А/46/30 тоот тушаалаар “E-halamj” цахим мэдээллийн нэгдсэн системийн үйлчилгээг нэвтрүүлэх*

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн ЗДТГ-ын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар 2020 онд тус байгууллагад дотоод хяналт хийгдээгүй, байна.

ХХҮЕГ газрын нэгдсэн удирдамжаар байгууллагын дотоод хяналт-үнэлгээ шинжилгээний багийн хийх ажлын төлөвлөгөөний дагуу хяналт шалгалт хийгдсэн, аймгийн Төрийн сангаас өдөр тутмын хяналт хэрэгжүүлсэн байна.

Байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр **нийт зардлыг** сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогоос 908351.2 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 9083.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Харин гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогоос 828245.4 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 8282.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 70801.8 мянган төгрөгөөр буюу 9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Тайлангийн үзүүлэлтүүд	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Авлага	5,691.2	4,077.8	(1,613.4)
Бараа материал	69,764.6	39,341.9	(30,422.7)
Үндсэн хөрөнгө	748,401.9	709,636.2	(38,765.7)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	823,857.7	753,055.9	(70,801.8)
Богино хугацаат өр төлбөр			-
Цэвэр хөрөнгө, өмч	823,857.7	753,055.9	(70,801.8)
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	823,857.7	753,055.9	(70,801.8)

Авлага дансны үлдэгдэл 4077.8 мянган төгрөг болж 1613.4 мянган төгрөгөөр буюу цалингийн урьдчилгаа, тэтгэмж, Цагаан уул сувиллын амралтын тооцооны авлагууд буурснаас шалтгаалсан, авлага бүрэн барагдах боломжтой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 39341.9 мянган төгрөг болж 30422.1 мянган төгрөгөөр буурсан нь байгууллагын өмч хамгаалах комиссын шийдвэрээр ашиглах боломжгүй БҮТЭЗ-ийг акталсан, шилжүүлсэн, зарцуулснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1107923.3 мянган төгрөг болж 17655.1 мянган төгрөгөөр өссөн нь харьяа дээд шатны байгууллагаас үнэ төлбөргүй хөрөнгийг шилжүүлэн өгсөнтэй холбоотой байна..

Үндсэн хөрөнгийн данс нь ХХҮЕГазрын хөрөнгө оруулалтаар 21494.0 мянган төгрөгийн, ХЭДС-аас 440.0 мянган төгрөгийн эд хариуцагчийн программыг үнэ төлбөргүй шилжүүлэн нийт 21934.0 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Тайлант онд ТӨБЗГ-ын 2016 оны 193 дугаар тогтоолоор аймгийн ХХААГазарт 4279.0 мянган төгрөгийн балансын үнэтэй үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй шилжүүлэх тухай тогтоол гарсан ч данс бүртгэлээс хасаагүй хөрөнгийг 2020 онд байгууллагын өмч хамгаалах

зөвлөл, тооллогын комисс, байгууллагын даргын А/113 тоот тушаалаар данс бүртгэлээс хассан байна.

Өр төлбөр данстай холбоотой оны эхэн болон эцэст үлдэгдэлгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 753056.0 мянган төгрөг болж 70801.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 70801.7 мянган төгрөгийн алдагдалтай гарснаас шалтгаалж байна.

Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 116207.4 мянган төгрөгөөр буюу 12.3 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 185340.4 мянган төгрөгийн буурсан нь холбогдох дээд шатны байгууллагаас тайлант онд шилжүүлэн хөрөнгө багассантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 63600.2 мянган төгрөгөөр буюу 6.6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс болон нэмэгдэл урамшил, шимтгэлийн зардал 87627.9, тогтмол зардал 4517.8, орон нутгийн төсөвт 5138.0 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн, эд хогшил, урсгал засварын зардал 8788.9 мянган төгрөгөөр тус тус өссөн, хангамж, бараа материалын зардал 109976.0, норматив зардал 31220.8, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал 10131.1, бараа үйлчилгээний бусад зардал 7851.7, урсгал шилжүүлэг 2912.5, дотоод томилолтын зардал 7580.6 мянган төгрөгөөр тус тус буурчээ.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар тайлант оны үр дүн 70801.7 мянган төгрөгийн алдагдалтай байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 971731.7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 971731.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 803333.5 мянган төгрөгийн төсөв баталснаас 736030.9 мянган төгрөгийн улсын төсвөөс, 67302.6 мянган төгрөгөөр туслах үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 736030.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, туслах үйл ажиллагааны орлого 40504.0 мянган төгрөг, нийт 736435.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 732953.4 мянган төгрөгийг зарцуулж 3482.5 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн, туслах үйл ажиллагааны орлогыг батлагдсан төлөвлөгөөнөөс 26798.6 мянган төгрөгөөр дутуу бүрдүүлсэн нь Ковид-19 цар тахалтай гарснаас шалтгаалан ахмадын амралт сувиллын үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 773543.4 мянган төгрөг буюу 96.3 хувьтай байгаа нь хангамж, бараа материалын зардал 1025.9, нормативт зардал 11394.1, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж 11636.9, эд хогшил худалдан авах

зардал 2480.2, урсгал шилжүүлэг 3253.0 мянган төгрөг нийт 29790.1 хэмнэсэн нь туслах үйл ажиллагааны орлого бүрэн бүрдүүлээгүйгээс шалтгаалсан байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээ 29790.1 мянган төгрөгөөр хэмнэсэн байна. Хэмнэсэн шалтгаан нь 2020 онд Ковид-19 цар тахалтай холбоотой ахмадын сувиллын үйл ажиллагаа явагдаагүй, туслах үйл ажиллагааны орлогыг 26798.6 мянган төгрөгөөр бүрдүүлж чадаагүйгээс шалтгаалсан байна.

Хүснэгт 3	Хөтөлбөр, арга хэмжээний хэмнэлт	/мян.төг/
код	хөтөлбөр, арга хэмжээ	мөнгөн дүн
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	229.5
80103	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний зардал	26,307.6
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	3,253.0
	ДҮН	29,790.1

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Халамжийн сангаас өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгааны зардал 16925.0, ХЭДС-аас залуучуудын гарааны бизнесийг дэмжих төсөл хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах сургалтад 9790.5, цахим тендерийн орлого 56.0, Дэлхийн банкны санхүүжилтээр “E-halamj” сургалтын зардалд 261.0, Швейцарын хөгжлийн агентлагаас 763.0 мянган нийт 27795.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаанд 10684.5, “E-halamj” - I, II сургалтад 3005.0, Залуучуудын гарааны бизнесийн сургалт сурталчилгааны зардалд 9790.5 мянган төгрөг буюу нийт 23480.0 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 4315.5 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 142 мэдээллээс хугацаандаа мэдээлсэн, хугацаа хоцроосон 5 мэдээлэл байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 500.0 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгөгдөж зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 13097.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 9020.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 4077.8 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа:

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Ковид-19 цар тахалтай холбоотой аж ахуйн нэгж байгууллага, иргэдээс хандиваар ирсэн 9020.0 мянган төгрөгийн бараа материалыг бүртгээгүй орхигдуулсныг аудитын явцад залруулга хийгдлээ.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт асуудлын бүртгэлээр танилцуулж **9020.0** мянган төгрөгийн залруулга хийж, залруулсан албан тоот ирүүлсэн болно.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 4077.8 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Анхаарал татахуйц асуудалгүй байна.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Бараа материалын данстай холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Бэлтгэн нийлүүлэгч байгууллагатай хийх гэрээнд холбогдох заалтын нарийн тусгаагүй, жолоочийн замын тооцооны хуудсанд хөдөө сумдад ажилласнаар тооцсон ч цагийн бүртгэлд нарийвчлан бүртгээгүй зөрчил байна.
- 1.2. Эрсдэл: Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлээгүй байх, гэрээнд холбогдох заалтыг оруулаагүй байх
- 1.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.3-д "жинхэнэ хэрэгжилтийн" гэсэн заалтуудыг мөрдөн ажиллах
- 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

2. Авлага данстай холбоотой асуудал

- 2.1. Илрүүлэлт: Өмнөх онуудад үүссэн 4077.8 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна.
- 2.2. Эрсдэл: Авлага барагдуулаагүй байх
- 2.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх" гэсэн заалтыг мөрдөн ажиллах
- 2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

Огноо:	Аудитын нэр:	Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			ХОА-2021/83/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Бэлтгэн нийлүүлэгч байгууллагатай хийх гэрээнд холбогдох заалтын нарийн тусгаагүй, жолоочийн замын тооцооны хуудсанд хөдөө сумдад ажилласнаар тооцсон ч цагийн бүртгэлд нарийвчлан бүртгээгүй	0	Зөвлөмж өгөх	Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын дарга, нягтлан бодогч	Л.Билэгдэмбэрэл, Х.Цэцэгбал
2	Ковид-19 цар тахалтай холбоотой аж ахуйн нэгж байгууллага, иргэдээс хандиваар ирсэн бараа материалыг бүртгээгүй орхигдуулсан	9020.0	Залруулга хийх		
3	Санхүүгийн тайлан дахь авлагыг барагдуулах	4077.8	Зөвлөмж өгөх		
ДҮН		13097.8			

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

